

Монгол Улсын Их Хурлын Хууль
зүйн байнгын хорооны 2026 оны ...
дугаар сарын ... -ны өдрийн
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	Эцэг/эхийн нэр: Сүрэнжав Ургийн овог: Дархчуул Нэр: Ганзориг Хүйс: эрэгтэй Төрсөн он: 1985 он [redacted] Төрсөн газар: Завхан аймгийн Отгон сум Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, [redacted]
1.2	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Тийм
1.3	Насны дээд хязгаар Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Үгүй. 40 настай. Иргэний үнэмлэхийн лавлагаа хавсаргав.
1.4	Шүүгчийн албан тушаал Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.5	Улс төрийн болон намын удирдах албан тушаал Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. Үгүй
1.6	Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

	Үгүй. ЦЕГ-ын тодорхойлолт хавсаргав.
1.7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	Үгүй
1.8	Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.
	Үгүй

ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд шүүхийн хараат бус байдлыг хангах нь иргэн бүрийн шударгаар шүүлгэх эрх, хүний эрх, эрх чөлөөний үндсэн баталгаа гэж үздэг. Хүний эрхийн хамгаалалт нь зөвхөн хууль тогтоомжоор бус, хараат бус, шударга, хүртээмжтэй шүүхийн тогтолцоогоор бодитоор хэрэгждэг. Иймээс төрийн албанд ажиллаж олж авсан мэдлэг, туршлагаа шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжил, шинэчлэл, хүний эрхэд суурилсан шүүхийн тогтолцоог бэхжүүлэх үйл хэрэгт зориулах хүсэл эрмэлзэлтэйгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрээ дэвшүүлж байна.</p> <p>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”-д 2030 он гэхэд “хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоог төлөвшүүлэх”, 2040 он гэхэд “иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болох” зорилтыг тусгасан. Мөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогоор шүүхийн бие даасан байдал, хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх нь хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх үндсэн нөхцөл гэж үзэж байгаа бөгөөд уг зорилтыг бодит ажил хэрэг болгоход хувь нэмэр оруулах нь миний нэр дэвших үндсэн зорилго юм.</p> <p>Миний бие 2009 оноос төрийн албанд ажиллахдаа төрийн албаны мерит зарчим, хариуцлага, ёс зүй, хүний эрхийг дээдлэх зарчмыг баримтлан ажиллаж ирсэн. Төрийн захиргааны байгууллагад ажилласан туршлагадаа тулгуурлан шүүхийн захиргааны менежмент, хүний нөөцийн бодлого, байгууллагын зохион байгуулалт, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах,</p>
-----	--

иргэн төвтэй удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллах боломжтой гэж үзэж байна.

Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд цахим шилжилт онцгой ач холбогдолтой. Иймд шүүхийн цахим систем, мэдээллийн нэгдсэн сан, лавлагаа үйлчилгээ, хэргийн хөдөлгөөний удирдлагын системийг боловсронгуй болгох, “Цахим шүүх 2.0” системийн хөгжүүлэлт, хэрэглээг дэмжихэд идэвх санаачлагатай ажиллана. Иргэд шүүхийн үйлчилгээг цахимаар түргэн шуурхай авах, шүүхийн шийдвэр, мэдээлэлтэй ойлгомжтой байдлаар танилцах боломжийг нэмэгдүүлэх нь зөвхөн үйлчилгээний шинэчлэл бус, шүүхэд хандах эрхийг бодитоор хангах хүний эрхийн чухал баталгаа гэж болно үзэж байна.

Мөн шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэдэд ойлгомжтой мэдээлэл хүргэх, үйлчилгээний чирэгдлийг бууруулах нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Шүүхийн шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай, ойлгомжтой хүргэх нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, шударга ёсны талаарх ойлголтыг бэхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Шүүхийн ачаалал, шүүгчийн хөдөлмөрийн нөхцөл нь шүүн таслах ажиллагааны чанарт шууд нөлөөлдөг. Нэг шүүгчид ногдох хэргийн тоо их байгаа нь хэрэг шийдвэрлэх хугацаа удаашрах, улмаар иргэдийн шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх эрсдэлийг бий болгож байна. Иймээс шүүгчийн ажлын ачааллыг оновчтой хуваарилах, хүний нөөцийн бодлогыг сайжруулах, шүүхийн захиргааны ажилтны хөдөлмөрийн таатай орчныг бүрдүүлэх асуудалд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлэх, шүүхийн байр, орчны стандартыг шинэ шатанд гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Иргэн бүр хүндрэл, бэрхшээлгүйгээр шүүхээр үйлчлүүлэх нөхцөлийг бий болгож, шүүхийн орчин, нөхцөл, үйлчилгээ энэ шаардлагад нийцсэн байх ёстой. Ялангуяа тойргийн журмаар байгуулагдсан гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн орчин, үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийн тогтолцоог хөгжүүлэхэд бодитой анхаарал хандуулан ажиллах болно.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийн хүрээнд шүүгчийн сонгон шалгаруулалтын ил тод, шударга байдлыг бэхжүүлэх, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгуурыг боловсронгуй болгох, шүүхийн хүний нөөцийн бодлогыг тогтвортой хөгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцоно. Шүүхийн нэр хүнд, хараат бус байдал нь шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй шууд холбоотой тул энэ чиглэлд бодит шинэчлэл хийх шаардлагатай гэж үзэж байна.

	<p>Цахим орчин, сошиал платформын хэрэглээ нэмэгдэж байгаа өнөө үед хүний нэр төр, хувийн нууц, хувийн мэдээлэл, оюуны өмч, зохиогчийн эрх, инноваци, программ хангамж, дижитал контенттой холбоотой эдийн бус хөрөнгөтэй холбоотой маргаан цаашид нэмэгдэх хандлагатай байгаа тул энэ чиглэлээр мэргэшсэн шүүхийн чадавх, шүүгчийн сургалт, цахим нотлох баримтын үнэлгээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, маргааныг шуурхай, мэргэшсэн түвшинд шийдвэрлэх хэрэгцээ шаардлага бий болсон байна. Иймээс эдийн бус хөрөнгийн маргааны онцлогт нийцсэн шүүхийн практик, цахим нотлох баримтын үнэлгээний аргачлал, мэргэшсэн шүүгчийн чадавх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>Иймд шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, иргэдийн шударга ёсонд итгэх итгэлийг бэхжүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэн төвтэй, хүртээмжтэй, ил тод болгоход өөрийн мэдлэг, туршлага, ур чадвараа зориулан ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй тул Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрээ дэвшүүлж байна.</p>
--	---

ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолтын гол агуулга; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. <p>1. Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга (2025 оноос хойш одоог хүртэл ажиллаж байна) Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-2, Засгийн газрын XII байр</p> <p>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, гомдол мэдээллийг шийдвэрлэх ажлыг удирдан зохион байгуулах, хувийн мэдээлэл хамгаалах болон халдашгүй чөлөөтэй байх эрхийн талаар олон нийтэд мэдээлэл түгээх, зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, дотоод, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийг хөгжүүлэх, хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах, хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний эрхийн хамгаалалтыг хангах чиглэлээр бодлогын санал боловсруулах чиг үүрэгтэй. Уг албан тушаалд тавигдах шаардлага нь эрх зүйч байх шаардлагатай.</p> <p>Дээрх хугацаанд:</p>

- 1) Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир [REDACTED]
- 2) Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга Б.Эрдэнэбат /Холбоо барих [REDACTED]

Хамт ажиллаж байгаа:

- 1) Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн референт Х.Хулан / [REDACTED]
- 2) Хүний эрхийн үндэсний комиссын референт Э.Батжаргал /Холбоо [REDACTED]
- 3) Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн мэдээллийн аюулгүй байдлын шинжээч Ө.Энхтөр / [REDACTED]

2. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн удирдлага, зохион байгуулалтын газарт хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан зөвлөх 2024.10.25-2025.08.01

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Улсын Их Хурлын Тамгын газрын нэгдүгээр байр

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын бодлого, төлөвлөгөө, тайлан, төсөл, хөтөлбөр, дээд байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтэд дүн шинжилгээ хийх, үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлан мэдээ боловсруулах, удирдлагыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, дотоод хяналт шалгалтыг удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар санал, зөвлөмж гаргах, байгууллагын нэгжүүдийн төлөвлөгөө, тайлан нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан эсэх, бүтэц, агуулга, хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж, холбогдох албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, албан хэрэг хөтлөлт, архивын баримт бичгийн бүрдэл, стандарт, журамд нийцсэн байдлыг хянах чиг үүрэгтэй бөгөөд энэ албан тушаалд ажиллахын тулд эрх зүйч мэргэжил эзэмшсэн байх шаардлагатай.

Удирдах албан тушаалтан:

- 1) Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн удирдлага, зохион байгуулалтын газрын дарга Д.Онолт [REDACTED]
- 2) Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн судалгааны хэлтсийн дарга П.Түмэнцэцэг / [REDACTED]

Хамт ажиллаж байсан:

- 1) Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр / [REDACTED]
[REDACTED] Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Дүүрэнхишиг [REDACTED]
- 3) Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн хууль, эрх зүй, хүний нөөц хариуцсан ахлах референт Э.Цолмонжаргал /Холбоо барих утас: /
- 4) Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн номын сангийн эрхлэгч, референт Ц.Мөнх-Эрдэнэ [REDACTED]

3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны салбарын хяналтын газрын дарга 2023.01.12-2024.10.15

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, төв шуудан, Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны яамны байр

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Мэдээлэл, харилцаа холбооны шугам сүлжээ, холбооны барилга байгууламж, шуудан, радио долгион, технологи, үйлчилгээний чиглэлээр салбарын хууль тогтоомж, стандарт, эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөн зохион байгуулах, улсын байцаагчдын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөрчил дутагдлыг арилгуулах, салбарын хяналтын бодлого, төлөвлөгөө, тайлан, дүгнэлтийг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох байгууллага, иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Уг албан тушаалд тавигдах шаардлага нь эрх зүйч мэргэжил эзэмшсэн байх шаардлагатай.

Удирдах албан тушаалтан:

- 1) Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг / [redacted] /

Хамт ажиллаж байсан:

- 1) Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол / [redacted] /
[redacted] Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа [redacted]
- 3) Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын хүний нөөц хариуцсан шинжээч Ш.Ариунзул [redacted]
- 4) Цахим хөгжил, харилцаа холбооны яамны салбарын хяналтын газрын дарга мэдээлэл холбооны улсын байцаагч С.Шинэбаяр / [redacted] /

4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт захиргааны хэлтсийн дарга 2021.03.21-2022.05.10

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Ерөнхий сайд А.Амарын гудамж, Соёлын төв өргөө Г корпус

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Соёл, урлагийн газрын салбарын хууль тогтоомж, байгууллагын төрийн захиргааны болон хүний нөөцийн бодлого, санхүү, хөрөнгө оруулалт, статистик мэдээлэл, мэдээллийн сан, архив, албан хэрэг хөтлөлт, гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиг үүргийг удирдан зохион байгуулж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн, үр дүнтэй хэрэгжилтийг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сургалт, хөгжлийг дэмжих, салбарын мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн бодлого, төлөвлөлт, тайлан, зөвлөмж боловсруулах, олон нийтэд үнэн зөв мэдээлэл түгээх, агентлагийн даргыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэгээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Уг албан тушаалд эрх зүйч мэргэжилтэй байх шаардлага тавигдана.

Удирдах албан тушаалтан:

- 1) Соёл, урлагийн газрын дарга Н.Мөнхзул /Холбоо барих [redacted] /

Хамт ажиллаж байсан:

- 2) Соёл, урлагийн газрын урлаг, уран бүтээлийн газрын дарга С.Дэлгэрмаа [redacted]

- 3) Соёл, урлагийн газрын урлаг, уран бүтээлийн хэлтсийн тайз, дэлгэцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Дэлгэржаргал /Холбоо барих утас: [REDACTED]
- 4) Соёл, урлагийн газрын биет бус өвийн ажил хариуцсан мэргэжилтэн Ж.Ууганцэцэг /Холбоо барих утас: [REDACTED]
- 5) Соёл, урлагийн газрын эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Бүжлхам /Холбоо барих [REDACTED]

5. Оюуны өмчийн газарт зохиогчийн эрхийн хэлтсийн дарга 2022.02.11-2022.03.21

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх [REDACTED]

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:

Хамт ажиллаж байсан:

- 1) Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн хэлтсийн зохиогчийн эрхийн мэргэжилтэн М.Ариунболд / [REDACTED]
- 2) Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн хэлтсийн зохиогчийн эрхийн мэргэжилтэн С.Цоггэрэл / [REDACTED]

6. Оюуны өмчийн газрын захиргаа удирдлагын хэлтсийн дарга 2018.12.31-2022.02.11

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 13-р хороолол, Зүүн 4 зам, Оюуны өмчийн газрын байр

Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Оюуны өмчийн газрын захиргаа, санхүү, хүний нөөц, эрх зүй, гадаад харилцаа, мэдээллээр хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар зохион байгуулж, төрийн бодлого, хууль тогтоомж, байгууллагын стратеги, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, гэрээ, тайлан мэдээ, архив, бичиг хэрэг, өргөдөл гомдол, иргэн, байгууллагад үзүүлэх үйлчилгээ, албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн харилцааг хариуцан ажиллахын зэрэгцээ оюуны өмчийн салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, олон улсын хамтын ажиллагааг зохион байгуулах, агентлагийн даргыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэгээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Уг албан тушаалд эрх зүйч мэргэжил эзэмшсэн байх шаардлага тавигдана.

Удирдах албан тушаалтан:

- 1) Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх / [REDACTED] /
[REDACTED] Оюуны өмчийн газрын дарга Э.Эрдэнэсүрэн [REDACTED]

Хамт ажиллаж байсан:

- 1) Оюуны өмчийн газрын мэдээлэл, технологийн мэргэжилтэн Ч.Сод-Эрдэнэ / [REDACTED]
- 2) Оюуны өмчийн газрын ахлах нягтлан бодогч Э.Оюунцэцэг [REDACTED]
- 3) Оюуны өмчийн газрын эрх зүй, хүний нөөц хариусан мэргэжилтэн Ж.Даваасүрэн / [REDACTED]

7. Оюуны өмчийн газрын хяналтын хэлтэст хяналтын улсын байцаагч 2016.07.27-2018.07.02

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Мэдээлэл, технологийн үндэсний парк

	<p>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Оюуны өмчийн газрын хяналтын чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон холбогдох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, дүгнэлт, акт гаргах, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, дээд шатны байгууллага, албан тушаалтны өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, эрх зүйч мэргэжил эзэмшсэн байхыг шаардана.</p> <p>8. Оюуны өмчийн газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн хүний нөөц, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн 2011.10-2016.07.27 Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Мэдээлэл, технологийн үндэсний парк</p> <p>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Байгууллагын эрх зүй, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих, эрх зүй, хүний нөөцийн чиглэлээр холбогдох хууль тогтоомж, удирдлагын тушаал шийдвэр, заавар зөвлөгөөг таниулах, биелэлтийг хангуулах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үндсэн чиг үүргийг гүйцэтгэх ба тухайн албан тушаалд эрх зүйч байх шаардлага тавигдана.</p> <p>9. Оюуны өмчийн газрын хяналтын хэлтсийн улсын байцаагч 2009.12.11-2014.11.10 Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Мэдээлэл, технологийн үндэсний парк</p> <p>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга: Оюуны өмчийн улсын хяналтын үйл ажиллагааг гүйцэтгэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, оюуны өмчийн зөрчлийн статистикийн мэдээ гаргах, зар сурталчилгааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан зөрчлүүдийг шалган шийдвэрлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>10. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/26 дугаартай тушаалын дагуу Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комиссын даргын албан тушаалыг 2019-2021 оны хооронд гүйцэтгэсэн. Мөн 2014-2016 оны хооронд Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комиссын нарийн бичгийн даргын албан тушаалд ажилласан.</p>
3.2	<p>Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>Эрхэлж байгаагүй.</p>
3.3	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар</p>

<p>болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p>
<p>Гишүүнчлэл байхгүй.</p>

ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<p>4.1</p>	<p>Хууль зүйн өндөр мэргэшил Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. <p>I. 2018-2024 онд Их Засаг Олон улсын их сургуулийн шинжлэх ухааны сургуульд “Барааны тэмдэг түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдвээр Хууль зүйн доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан. Удирдсан багш: Хууль зүйн доктор /Ph.D/, профессор Г.Ууганболор, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор Г.Туяа Шүүмжлэгч багш: Хууль зүйн доктор /Dr.Jur/, профессор Д.Сүнжид, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор Д.Эрдэнэчимэг</p> <p>II. 2010-2012 оны хооронд Их Засаг их сургуульд эрх зүйн магистраар суралцан төгссөн бөгөөд 2013 оноос хойш тус сургуульд оюуны өмчийн эрх зүйн чиглэлээр 13 дахь жилдээ цагийн багшаар ажиллаж байна.</p> <p>Удирдах албан тушаал:</p> <ol style="list-style-type: none"> 1) Их засаг Олон улсын их сургуулийн проректор Ж.Цэцэгмаа /Холбоо барих утас: 99116486/ 2) Их засаг Олон улсын их сургуулийн маркетинг, оюутны хөгжил хариуцсан проректор Б.Мэндбаяр / [redacted] / 3) Их засаг Олон улсын их сургуулийн проректор Г.Туяа [redacted] <p>Хамт ажиллаж байсан:</p> <ol style="list-style-type: none"> 1) Доктор /Ph.D/, дэд профессор Д.Одгэрэл /Холбоо барих утас: [redacted] 2) Хууль зүйн сургуулийн захирал Ц.Алтангэрэл /Холбоо барих утас: [redacted]
-------------------	---

	<p>III. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн ажил:</p> <p>Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2020.02.02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т гишүүнээр орж ажилласан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн ажлын хэсэг байгуулах тухай 157 дугаар захирамжийг үндэслэн “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын дэд хэсэг”-т гишүүнээр орж ажилласан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2019.06.10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор байгуулагдсан “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т гишүүнээр орж ажилласан.</p>
<p>4.2</p>	<p>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.</p>
	<p>I. Дангаар болон хамтран хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл:</p> <p>1. С.Ганзориг “Барааны тэмдгийн түүхэн уламжлал, онцлог”.,эрдэм шинжилгээний өгүүлэл.,Дотоод хэргийн их сургуулийн “Хууль сахиулахуй” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл,..2022 он, №4;</p>

2. С.Ганзориг “Барааны тэмдгийн зөрчилтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, “Их Засаг сэтгүүл” эрдэм шинжилгээ, судалгаа, арга зүй, 2022 он №21;
<https://online.fliphtml5.com/ixfpp/itvh/#p=1>
3. С.Ганзориг “Барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй зарим асуудал”, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2023 оны II улирлын 93-р дугаар
chrome-extension://efaidnbnmnnibpcajpcglclefindmkaj/https://nli.gov.mn/wp-content/uploads/2025/03/HDY-setguul-2.pdf
4. С.Ганзориг “Монгол Улсын барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалт”, Chonbuk National University “Chonbuk law review”, 2023, Vol.72
5. Г.Ууганболор, С.Ганзориг “Барааны тэмдгийн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зам”. Хятадын шинжлэх ухаан, технологийн сэтгүүл, БНХАУ, 2024 он [浅析商标侵权中"商标性使用"的认定-期刊网](#)
6. Г.Ууганболор, С.Ганзориг “Монгол Улс дахь барааны тэмдгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. Хятадын шинжлэх ухаан, технологийн сэтгүүл, БНХАУ, 2024 он [蒙古商标法律监管的现状与展望-期刊网](#)

II. Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал

1. Оюуны өмчийн газар “Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд орж буй талаарх судалгааны ажил”(албан хэрэгцээнд зориулав).УБ.,2021 он
Цахим линк: [ОӨГ-г эдийн засгийг эргэлтэд оруулах судалгааны тайлан .pdf - Google Drive](#)
2. Хүний эрхийн үндэсний комисс “Хүний эрх ба цахим технологи олон нийтийн хяналт шалгалтын тайлан”, УБ.,2026 он;

III. Судалгааны ажлын шүүмж

1. Магистрант Ванг Кай Лонг “Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” 2025 оны 12 дугаар сар
2. Магистрант Д.Батцэцэг “Өв залгамжлал, түүний эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик”, магистрын зэрэг горилсон бүтээлд өгсөн шүүмж 2026 оны 05 дугаар сар

IV. Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэл:

1. “Хууль батлагдсан тохиолдолд Оюуны өмчөө барьцаалах, хувьцаа гаргах, даатгалд хамруулах боломж бүрдэх юм” Eagle news телевиз ярилцлага 2020.01.01
2. “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар” equur.mn сайтын ярилцлага 2020.04.25 <https://equur.mn/97057/>
3. “Хүний хувийн мэдээлэл талаарх иргэдийн ойлголтын талаарх мэдээлэл”.Өдрийн сонин ярилцлага 2025.11.17
<https://www.facebook.com/photo/?fbid=1404622108330048&set=a.527715892687345>
4. “Албан байгууллагуудын хүний нөөцийн ажилтнууд хүний хувийн мэдээллийг хадгалах, хамгаалах асуудалд онцгой анхаарах

	<p>шаардлагатай байна” цахиур.mn сайтын ярилцлага 2025.11 сар https://www.facebook.com/reel/1442036993682126</p> <p>5. “AI камер ашиглаж эхэлсэн нь иргэний суурь эрхүүдтэй шууд холбоотой учир анхаарах шаардлагатай” graph.mn сайтын ярилцлага 2025 он https://www.facebook.com/reel/2186302185111413</p> <p>6. Хүний эрхийн Үндэсний комиссоос зохион байгуулсан “Хүний эрх ба цахим технологи” хяналт шалгалтын тайлангийн талаарх мэдээлэл” сэдвээр Eagle news телевизийн мэдээнд өгсөн ярилцлага 2026.05.14 https://www.facebook.com/reel/1329105215760686</p> <p>7. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн талаар Eagle news телевизийн зочны цаг нэвтрүүлэгт өгсөн ярилцлага 2026.05.14 https://www.facebook.com/reel/809327485338915</p>
4.3	<p>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ) Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
4.4	<p>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.</p> <p>1. 2018-2024 онд Их Засаг Олон улсын их сургуулийн шинжлэх ухааны сургуульд “Барааны тэмдэг түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдвээр Хууль зүйн доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан;</p> <p>2. 2010-2012 онд Их Засаг их сургуульд эрх зүйн магистрын зэрэг хамгаалсан;</p>
4.5	<p>Сахилгын шийтгэл Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>

Хавсралт:

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

-эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын

хуулбар;

-хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

-эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;

-энэхүү загварт заасан баримт бичиг;

-холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр:.....

Өөрийн нэр: Ганзориг

Гарын үсэг:

Он, сар, өдөр:

---oOo---